



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Салбарын жендэрийн бодлогыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дүгээр заалт, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дугаар заалт, Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн банк хоорондын 2016 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан "Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа" техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт баримтлах жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан бодлого болон холбогдох хууль тогтоомжийг баримтлан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Эрдэнэд үүрэг болгосугай.

САЙД




Г.ЧУЛУУНБААТАР



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2017 оны 8-дугаар сарын 24-ний
өдрийн 130 дугаар тушаалын хавсралт



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

(2017-2024)

Нэр томъёоны товч тайлбар

- 1. Жендэрийн мэдрэмж:** эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар.
- 2. Жендэрийн тэгш байдал:** эмэгтэй эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж, хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдсан байх.
- 3. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах (*Gender mainstreaming*):** бүх хүрээ, бүх түвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги.
- 4. Жендэрийн статистик:** хүйсээр ангилсан тоон мэдээлэл болон тухайн цаг үеийн нийгмийн хэрэгцээнд тохирсон арга хэрэгслийн тусламжтайгаар жендэрийн хэвшмэл сэтгэлгээг, улмаар тэгш шударга бус нөхцөл байдлыг өөрчлөхөд чиглэсэн бодлого боловсруулах үйл явц.
- 5. Жендэрийн дүн шинжилгээ:** бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц.
- 6. Жендэрийн хяналтын хуудас:** аливаа бодлого хөтөлбөр, үйл ажиллагааны үе шат бүрт жендэрийн нөхцөл шалгах асуултын жагсаалт, эсхүл жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх ажлыг хариуцан хийж байгаа хүмүүсийн тухайн ажлын хүрээнд хүлээсэн үүрэг даалгавраа бүрэн гүйцэтгэж байгаа эсэхээ хянахад ашиглах жагсаалт.

Өмнөх үг

Жендэрийн тэгш байдлыг хангах нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийг, охид хөвгүүдийг тэнцүү тоогоор оролцуулах төдий биш бөгөөд, эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд хөгжлийн үйл явцад оролцох болон түүний үр шимээс хүртэхэд тулгарч буй саад бэрхшээлийг судлан илрүүлж арилгах үйл явц юм. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ нь улс орны, салбарын өмнө тавигдаж буй зорилт, төлөвлөсөн үйл ажиллагааг илүү оновчтой, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Жендэрийн тэгш байдлыг хангах нь тухайн салбар, байгууллагын нэмэлт буюу "дайвар" ажил биш, харин үндсэн ажил үүргүүдийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг, нэгэн "амин судас" болж, бодлого боловсруулах, төлөвлөлт болон төсөвлөлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэл, үр нөлөөг хянаж үнэлэх бүх шатанд харгалзаж үзсэнээр биеллээ олдог.

НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын төрөлжсөн байгууллага ЮНЕСКО боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын салбарт тулгарч буй жендэрийн тэгш бус байдлыг арилгах нь 21-р зууны хүн төрөлхтний хойшлуулшгүй, шийдвэрлэх асуудлын нэг хэмээн үзэж, 2014-2021 он хүртэлх Жендэрийн тэгш байдлыг хангах тэргүүлэх чиглэлийг батлан, Тогтвортой хөгжлийн зорилтуудтай үйл ажиллагаагаа нэгтгэн ажиллаж байна.

Уг чиглэлд соёлын амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрх, үүрэгтэйгээр оролцохыг дэмжих, тус салбарыг хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн зүгээс оруулж буй хувь нэмрийг үнэлэх, байгалийн шинжлэх ухааны чиглэлээрх төсөл, хөтөлбөрүүдэд эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх, эмэгтэй эрдэмтдийн мэргэжлийн сүлжээг дэмжих, шинжлэх ухааны бодлогын шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Хүн бүрт тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролыг олгох талаарх Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэхэд спортын үүрэг оролцоог "Боловсрол, спортын нэгдмэл үйл ажиллагаа нь хамран сургалтыг нэмэгдүүлж, анги дэвших үзүүлэлтийг дээшлүүлэх төдийгүй сургалтын амжилтад нөлөөлнө" гэж тодорхойлсон байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хууль (2011)-д соёл, боловсролын хүрээн дэх жендэрийн тэгш байдлыг онцлон анхаарч, Жендэрийн үндэсний шинэ хөтөлбөр (2017)-т жендэрийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгарлыг боловсролоор дамжуулан арилгах, багш бэлтгэх сургууль болон бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, сурах бичигт жендэрийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааг төлөвлөөд байна.

Монгол улсын боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын байгууллага, ажилтан албан хаагчид нэгдмэл бодлого, үйл ажиллагаагаараа монгол хүнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдарын хувьд өв тэгш хүмүүжүүлэн боловсруулахын төлөө ажиллаж байна. Салбарын жендэрийн нэгдсэн бодлого нь тэдний энэхүү зорилго, үйл ажиллагааг жендэрийн арга зүйгээр дэмжин, тулгамдсан асуудлыг шийдэх гарц, арга замыг олох, хэрэгжүүлэхэд дэмжлэг болно хэмээн найдаж байна.

Жендэрийн зөвлөх баг

Нэг. Нийтлэг үндэслэл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого нь (цаашид "Салбарын жендэрийн бодлого" гэнэ) салбарын хөгжлийн бодлогын үйл явцад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээг тогтоон хэрэгжилтийг тодорхойлсон дунд хугацааны хөгжлийн төлөвлөлт юм.

Энэхүү салбарын жендэрийн бодлого нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021), Төрөөс боловсролын (2013), соёлын (2012), шинжлэх ухаан, технологийн (1998) талаар баримтлах бодлого, биеийн тамир спортыг 2011-2020 онд хөгжүүлэх цогц хөтөлбөр (2011)-тэй уялдан хэрэгжинэ.

Салбарын жендэрийн бодлогыг жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр боловсролын салбарт хэрэгжүүлж ирсэн санаачлага, төсөл, үйл ажиллагааны үр дүн, сургамж, сүүлийн үеийн судалгаа шинжилгээний зөвлөмж, мөн жендэрийн нэгдсэн бодлого боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн салбарын ажилтан, албан хаагчдын жендэрийн пракик ба стратеги хэрэгцээг тодорхойлох зорилгоор 2017 оны 4-6-р сард хийгдсэн "Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ", салбарын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан боловсруулав.

Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээгээр жендэрийн чиглэлээр хийгдсэн судалгаа шинжилгээний зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт өнөөдөр тулгамдаж буй жендэрийн асуудлыг шийдэхийн тулд салбарын жендэрийн асуудлыг бүх түвшинд уялдуулан зохицуулах чадамж бүхий тогтвортой ажиллах бүтэц, тогтолцоог бүрдүүлж, хүний нөөц бэлтгэх шаардлагатай байгаа нь илэрсэн. Иймд салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох бодит нөхцөл бололцоо бүрдүүлэхийн тулд юуны өмнө салбарын удирдах ажилтан, бодлого төлөвлөлт, хяналт үнэлгээ, хүний нөөц, төсөв санхүүгийн асуудал хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдын ажлын байрны чиг үүргийн дагуу жендэрийн үе шаттай сургалтаар чадавхижуулах, боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын ажилтан, албан хаагчдыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд жендэрийн мэдлэг боловсрол олгох, жендэрийн судалгаа шинжилгээний арга зүйд сургах үйл ажиллагааг системтэй, үе шаттай хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

Юуны өмнө боловсролын салбарын суралцагч, ажилтан, албан хаагчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх ажлыг судлан эхлүүлэх шаардлага тавигдаж байна. Статистикийн мэдээллээс үзэхэд манай улсад охид хөвгүүд сургуулийн өмнөх, бага, суурь боловсролын үйлчилгээнд харьцангуй тэгш хамрагдаж байгаа ч, дээд боловсролын түвшинд мэргэжлийн чиглэлээр хүйсийн ялгаа их, ялангуяа боловсролын чиглэлийн мэргэжлээр суралцагчдын дунд эмэгтэйчүүд хэт давамгайлсан хэвээр байгаа нь хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн хэвтээ ялгарал цаашид үргэлжлэхийг харуулж байна. 2016-2017 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид нийтдээ 157, 138 оюутан элсэн суралцсаны 91, 526 буюу 58,2 хувь нь эмэгтэй байна. Мэргэжлийн чиглэлээр авч үзвэл суралцагчдын хүйсийн харьцаа харилцан адилгүй. Тухайлбал, бакалаврын түвшинд боловсролын мэргэжлээр 18,725 оюутан суралцаж байгаагийн 81.7 хувь нь эмэгтэй, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр суралцаж буй 15,767 оюутны 81.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Дээрх үзүүлэлтийг 2015-2016 оны хичээлийн жилтэй харьцуулахад эмэгтэй оюутны эзлэх хувийн жин бага зэрэг (1 хувь) нэмэгдсэн байна.

Харин мэдээлэл, харилцаа холбооны технологийн мэргэжлээр 3,884 суралцагч байгаагийн 27.7хувь нь эмэгтэй, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээх мэргэжлээр суралцаж буй 12,615 оюутан суралцагчдын дөнгөж 20,4 хувь нь эмэгтэй байгаа төдийгүй өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 2-8 хувь хүртэл буурсан байна.

Сургуулийн өмнөх боловсрол, бага дунд боловсролын багш нарын дунд эмэгтэйчүүд давамгайлах нь дэлхий нийтэд түгээмэл байдаг ч бусад улс оронтой

харьцуулахад манай улсын хувьд жендэрийн тэнцвэрт байдал хэт алдагдсан байна. Үүнд эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ажил мэргэжлийн талаарх жендэрийн хэвшмэл ойлголт, цалин хөлсний хэмжээ, нийгэм дэх үнэлэмж зэрэг хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын байгууллагуудын соёл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхдээ ажил-ар гэр, амьдралын тэнцвэрт байдал болон ажлын орчин, нөхцөл, салбарын бүх насны мэргэшсэн хүний нөөцийг дайчлан ажиллах шаардлага гарч байна. 2017 оны байдлаар СӨБ-д ажиллаж байгаа нийт багш, ажиллагчдын 96.0 хувь нь эмэгтэй байна. ЕБС-ийн үндсэн багш нарын 81.2 хувь нь эмэгтэй, 18.8 хувь нь эрэгтэй байна. ЕБС-ын сургуулийн захирлуудын 56.3 хувь нь эмэгтэйчүүд, харин их дээд сургууль, коллежийн захирлуудын 57 хувь нь эрэгтэйчүүд байна.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгэм эдийн засгийн салбарт эн тэгш хөдөлмөрлөх, тэдний эрхэлж буй ажил нийгэмд эн тэнцүү үнэлэгдэх боломжийг бүрдүүлэхийн тулд охид хөвгүүдийн мэргэжил эзэмшихэд төдийгүй “насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний зөрүүг багасгахад чиглэсэн боловсрол нөхөн олгох албан ба албан бус сургалтад хамрагдах, тасралтгүй боловсролын үйлчилгээг хүртэх тэгш боломж, нөхцөлөөр хангагдана” хэмээсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.


Нийгэм дэх орлогын ялгаа ихсэн нийгмийн бүлгүүдийн хооронд соёлын ялгарал нэмэгдэж буй энэ цаг үед олон янз байдал, жендэрийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрч дэмжихүйц үнэт зүйлийн цогцыг бүрдүүлэх, өндөр ёс суртахууныг өсвөр, залуу үед төлөвшүүлэхэд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн боловсролын салбарын бодлого, түүний хэрэгжилт тухайн салбарын суралцагчид, ажилтан, албан хаагчдаар хязгаарлагдахгүй, нийгмийн амьдралын бүх хүрээнд, түүний дотор ялангуяа хот суурин газрын орлого багатай болон хөдөөгийн айл өрхүүдийн амьдралын хэв маягт, тэдний эдийн засаг, санхүүгийн шийдвэрт нөлөөлж, хүн амын шилжих хөдөлгөөн, нягтрал суурьшилд нэгэн шийдвэрлэх хүчин зүйл болж байдаг бөгөөд эдгээр нь жендэрийн ямар агуулга, үр нөлөөтэй байгааг анхаарч судлах шаардлагатай байна.

Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, байр суурийн талаарх жендэрийн хэвшмэл ойлголт тэгш бус байдлыг үүсгэж бэхжүүлэгч гол хүчин зүйл болж байгаа нь Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратегийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, мөн боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээгээр харагдсан билээ. Уг хэвшмэл ойлголтыг арилгахад соёл, урлагийн салбарын үйл ажиллагаа чухал үүрэгтэй. Соёл, урлагийн салбарт ажиллагчдын хүйсийн харьцааны цаана байгаа мэргэжлийн сонголтод нөлөөлж буй хүчин зүйлс, жендэрийн нийцтэй ажлын орчны асуудал, мөн соёлын байгууллагууд, бие даасан уран бүтээлчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний жендэрийн агуулга, үр нөлөөг судлан, соёл судлал, соёлын бодлогын түвшинд жендэрийн асуудлыг анхаарч тусгах шаардлагатай байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарын хэмжээнд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь сүүлийн жилүүдэд өссөн хэдий ч мэргэжлийн чиглэл, салбараар хүйсийн ялгаа байсаар байгаа нь шинжлэх ухааны байгууллага, хүрээлэнгүүдийн өмнө тулгамдаж буй жендэрийн асуудал болж байна. Эрдэм шинжилгээний ажилтнуудыг салбар тус бүрээр авч үзвэл анагаах ухаанаас бусад бүх салбарт эрэгтэйчүүд зонхилж байна. Салбарын 147 удирдах ажилтны 58 нь буюу 39.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Жендэр судлалыг хөгжүүлэх, шинжлэх ухааны судалгаанд суурилсан мэдлэг мэдээллээр дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад хувь нэмэр оруулах асуудлыг салбарын бодлогын хүрээнд анхаарах хэрэгтэй байна.

Бүх нас, хүйсийн хүмүүст биеийн тамир спортын үйл ажиллагаанд оролцох, хичээллэх боломж олгон Тогтвортой хөгжлийн зорилгуудын “хэнийг ч үл орхигдуулах” зарчмыг хэрэгжүүлэхэд өнөөдөр хүмүүсийн нас хүйс, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийг

харгалзсан, тэдний ялгаатай хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын бодлого, арга хэмжээ, дэд бүтэц, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг дутагдаж байна. Өнөөгийн байдлаар манай улсын биеийн тамир, спортын 31 байгууллагад нийт 559 хүн ажиллаж байгаагаас 223 нь буюу 39.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд нийт 20664 цол, зэрэгтэй тамирчид байгаагийн дотор эрэгтэйчүүд давамгайлж (66.7 хувь) байна. Биеийн тамир, спортын чиглэлээр суралцагчдын дийлэнх нь эрэгтэй оюутан байна. Тухайлбал, МУБИС-ийн Урлаг, биеийн тамир спортын сургуульд 713 оюутан суралцаж байгаагаас 195 нь буюу 27.3 хувь нь эмэгтэй байгаагаас үзэхэд тус салбарт суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгцээтэй байна. Түүнчлэн ажлын байран дахь дарамт шахалт, ялангуяа бэлгийн дарамт нилээд байдгийг оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээнд оролцогчид онцлон дурьдаж байлаа.



Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн энэхүү салбар дундын бодлого, арга хэмжээ нь улс орны, салбарын өмнө тавигдаж буй зорилт, төлөвлөсөн үйл ажиллагааг илүү оновчтой, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төдийгүй боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар хууль тогтоомж, бодлогоо шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалтаас ангид болгоод зогсохгүй эдгээр хууль, тогтоомжийн үр нөлөө нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангаж чадаж буй эсэхэд анхаарч, учирч буй саад бэрхшээл, хүндрэлийг арилгах идэвхтэй арга хэмжээ авахад чиглэгдэнэ.

Хоёр. Бодлогын зорилго

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээний бүх түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцыг дэмжинэ.

Гурав. Бодлогын зорилт, үйл ажиллагааны чиглэл

Салбарын жендэрийн бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин, бүтэц тогтолцоог боловсронгуй болгох;

2. Салбарын бүх түвшний ажилтан, албан хаагчдын жөндөрийн тэгш байдлыг хангах талаарх мэдлэг, чадавхийг сайжруулах;
3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын бүх түвшний байгууллагад жөндөрийн нийцтэй орчинг бүрдүүлэх;
4. Жөндөрийн тэгш байдлыг хангахад саад болж буй хэвшмэл ойлголтыг өөрчлөх үйл явцыг манлайлах.

Зорилт 1-ийн хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 1.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хэрэгжиж байгаа болон шинээр боловсруулах хууль, эрх зүйн акт, дүрэм, журмын жөндөрийн мэдрэмжийг сайжруулах;
- 1.2 Салбарын жөндөрийн тэгш байдлыг хангах бүтэц тогтолцоо, механизмыг бэхжүүлэх;
- 1.3 Салбарын бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх үйл явцад жөндөрийн хандлагыг төлөвшүүлэх;
- 1.4 Хүйсээр ангилсан мэдээллийн сан, түүний ашиглалтыг сайжруулж, жөндөрийн дүн шинжилгээг хөгжүүлэх.

Зорилт 2-ын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 2.1 Салбарын нийт удирдах албан тушаалтны жөндөрийн тэгш байдлыг хангах үйл явцыг манлайлан хэрэгжүүлэх үүрэг хариуцлага, чадавхийг дээшлүүлэх;
- 2.2 Салбарын мэргэжилтнүүдийн жөндөрийн дүн шинжилгээнд суурилсан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх арга барил, ур чадварыг сайжруулах;
- 2.3 Боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, биеийн тамир спортын салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх бүх хөтөлбөрт жөндөрийн агуулгыг тусгах.

Зорилт 3-ын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 3.1 Ялгаатай байдлыг хүндэтгэж, ялгаварлан гадуурхал, дарамт хүчирхийллийг үл тэвчих тогтолцоо, байгууллагын соёл бүх түвшинд хөгжүүлэх;
- 3.2 Эмэгтэй эрэгтэй ажилтан, албан хаагчдын ялгаатай хэрэгцээнд нийцсэн, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангасан ажиллах орчин бүрдүүлэх;
- 3.3 Жөндөрийн нийцтэй суралцах орчинг бүх шатны сургалтын байгууллагад бий болгох;
- 3.4 Салбарын удирдах ажилтан, багш, суралцагчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх.

Зорилт 4-ын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.1. Насан туршийн боловсролын тогтолцоо болон хэвлэл мэдээллээр дамжуулан бүх нийтийн жөндөрийн боловсролыг дээшлүүлэх;
- 4.2. Жөндөрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ, санаачлагыг дэмжих.

Дөрөв. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа

Бодлогыг 2017-2024 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Эхний үе шат буюу 2017-2020: Энэ үе шат нь Засгийн газраас 2017-2021 онд хэрэгжүүлэх "Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийн үйл ажиллагааны хэрэгжилттэй уялдана.

Хоёрдахь үе шат буюу 2021-2024: Энэ үе шат нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ийн хэрэгжилттэй уялдана.

Тав. Бодлогыг хэрэгжүүлэх төсөв, хөрөнгийн эх үүсвэр

Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- Хандивлагч улс, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;

- Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;
- Бусад.

Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр нарийвчлан гаргаж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлдэг хамтын гэрээ байгуулсан олон улсын болон бусад байгууллагуудын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, дэмжлэгийнхээ хоёр хувийг тус бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлнэ.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Бодлогын хэрэгжилтийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар ахлуулсан Жендэрийн салбар зөвлөл удирдан зохион байгуулна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Бодлогын арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Жендэрийн салбар зөвлөлд танилцуулна.

Бодлогын эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг 2021 оны эхний улиралд багтаан үнэлж, хоёрдугаар шатанд авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

—oOo—